



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр  
сарын 17-ны өдөр


Дугаар 150

Улаанбаатар  
хот

Улсын үзлэг зохион байгуулах тухай

Архивын тухай хуулийн 9.2.1, 9.2.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулахыг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатарт даалгасугай.
2. Улсын үзлэг зохион байгуулахад шаардагдах 65.129.375 (жаран таван сая нэг зуун хорин есөн мянга гурван зуун далан таван) төгрөгийг 2019 оны төсвийн зохих зардлаас санхүүжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид зөвшөөрсүгэй.
3. Улсын үзлэгийн нэгдсэн дүнг 2020 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Хууль зүй, дотоод хэргийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ц.НЯМДОРЖ